

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙГООР  
ХУУЛЬ ХООРООНДЫН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ЗОРИЛГООР  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН БУСАД ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ  
ЭСЭХ ТАЛААРХ ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Инновац, цахим бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийн хүчинтэй байдлыг хүлээн зөвшөөрөх, нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх нөхцөлийг бүрдүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хуулийн төслүүд батлагдсанаар өөрийн батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжтой бөгөөд, нийгэм, эдийн засагт сөрөг үр дагаваргүй гэж хууль санаачлагч үзсэн байна. Инновац, цахим бодлогын байнгын хороо хуулийн төслүүдийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг дээрх хуулийн төслүүд батлагдсанаар цахим шилжилтийг бүрэн хийх боломжтой эсэх, цахим албан хэрэг хөтлөлтийн системийг төрийн бүх байгууллагууд нэвтрүүлж, архивлах боломжтой эсэх, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрч нотлох баримтын хэмжээнд үнэлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн байдал, төрийн албан тушаалтнуудын шийдвэрийг иргэдэд энгийн байдлаар хэрхэн хүргэх, шийдвэртэй танилцах бололцоотой эсэх, банк, и-монгол, нотариатын үйлчилгээний хэрэгжилт, үүрэн холбооны сүлжээг орон нутгийн алслагдсан байршилаас хамаарахгүйгээр технологийн дэвшилийг нэвтрүүлж байгаа эсэх, цахим архивын аюулгүй байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам газрын мэдээллийн сан, төрийн болон орон нутгийн өмчийн зуслангийн газрын

хувьчлалын мэдээллийг нээлттэй ил тод болгох эсэх, боловсролын баримт бичгийг олон улсын стандартын дагуу цахим хэлбэрээр архивлах, иргэдэд цахим хэлбэрээр олгох эсэх, кибер аюулгүй байдлыг хангах нөхцөл, тоног төхөөрөмж, хүний нөөц бэлэн байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал сонгуулийн хуулийн төсөлтэй холбоотойгоор үндэсний бүртгэлийн системийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, үндэсний data программыг сайжруулах судалгаа байгаа эсэх, сонгуулийн сурталчилгааны мэдээллийг иргэн бүрд түгээх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар иргэний үнэмлэх дээрх тоон гарын үсгээ бүрэн ашиглах боломжтой эсэх, цахим гарын үсгийн ашиглах тоон төхөөрөмж хангалттай эсэх, "E-business" платформ бий болсноор иргэд компани байгуулж, энгийн болон тусгай зөвшөөрлийг цахимаар авах, сунгах бололцоотой эсэх, нотариатын үйлчилгээг иргэдэд цахимаар бүрэн хүргэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн эрүүл мэндийн салбарын зөвшөөрлийг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх, цахим орчинд тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд хуулийн төслүүдийг хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Монгол Улс цахим үндэстэн болох зорилтын хүрээнд цахим хөгжлийг дэмжих хуулиуд батлагдсантай холбогдуулан нийт 60 орчим төр, хувийн хэвшлийн байгууллагын удирдлагуудтай уулзалт хийж хуулийн хэрэгжилтийн явцтай танилцаж, цаашид хэрэгжилтийг улам эрчимжүүлэх талаар, мөн дээрх хуулийн өөрчлөлтийг дэмжиж байгаа талаар үг хэлсэн болно.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

